



**БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2015 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 4/02

Булган

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгэр зүйлийн 29.1.1."а", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1. дэхь заалтууд, Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоол, Зам, тээврийн сайдын 2015 оны 53, 65, Төрийн өмчийн хорооны даргын 2015 оны А/61 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг Тээвэр, авто замын газрыг "Авто тээврийн үндэсний төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газарт нэгтгэн зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга	Д.Чимгээ	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	А.Ганболд	Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Одхүү	Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Баттуяа	ТЗУХ-ийн мэргэжилтэн
	Г.Дэлгэрмаа	СТСХ-ийн мэргэжилтэн
	Ц.Энхжаргал	Өмчийн албаны дарга
	Д.Нарангэрэл	Тээвэр, авто замын газрын дарга
	Н.Амгалан	"Автотээврийн үндэсний төв" аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газрын Булган аймаг дахь салбарын дарга
	Б.Батсайхан	Тээвэр, авто замын газрын нягтлан бодогч
	Д.Нансал	"Автотээврийн үндэсний төв" аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газрын Булган аймаг дахь салбарын нягтлан бодогч
	М.Саруулзам	Архивын тасгийн дарга

Хоёр. Нэгтгэн зохион байгуулалтад орсонтой холбогдуулан тус газрын ажилтнуудын цалин, хөлс, үйл ажиллагааны зардал, тэтгэмж, ажилтнуудыг шилжүүлэх, архив, албан хэрэг хөтлөлт, өмч, үүссэн өр авлагыг тооцоо нийлэн баталгаажуулж, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-т шилжүүлэх ажлыг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний дотор зохион байгуулж, танилцуулахыг ажлын хэсэг /Д.Чимгээ/-г даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ӨРДЭНЭБАТ